



**ОРХОН АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 дугаар сарын 31

Дугаар 02/29

Жаргалант сум

Г "Ногоон Жаргалант" хөтөлбөрийн Г  
2025 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгүүдийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1."Ногоон Жаргалант" хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Засаг дарга (Л.Учрал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны  
12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдааны  
02.18 дугаар тогтоолын хавсралт

НОГООН ЖАРГАЛАНТ ХӨТӨЛБӨРИЙН  
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.12.20

Жаргалант

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Санхүүжилтийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хариуцагч
					Он	Түвшин		
Зорилт 1: Хог хаягдлын менежментийг сайжруулах								
1	Орчны бохирдлыг бууруулах	8.0	ОНТ	Хамрагдсан иргэдийн тоо	2024	Хог цэвэрлэгээний ажлыг 4 удаа зохион байгуулсан	8 удаа зохион байгуулна	ЗДТГ, Иргэн аж ахуй нэгж, төрийн байгуулга
2	Төвлөрсөн хогийн цэгийн хэвийн үйл ажиллагааг хангах	33.0	ОНТ	Зохион байгуулсан тоо	2024	2024 онд төвлөрсөн хогийн цэгийн 4 га талбайн түрж тэгшлэх ажлыг 4 удаа зохион байгуулсан.	Түрж тэгшлэх ажлыг 8 удаа зохион байгуулсан	ЗДТГ Нийтлэг үйлчилгээ-ний алба
3	Золбин гэх тодотгол бүхий нохдын устгалын ажлыг зохион байгуулах тоо толгойг цөөрүүлэх, тэжээвэр нохойг пайзжуулах, нохойн үржил хаах ажилбарыг зохион байгуулах	20.0	ОНТ	Зохион байгуулсан тоо	2024	2024 онд золбин нохойн устгалын ажлыг 6 удаа зохион байгуулсан	устгалын ажлыг 10 удаа зохион байгуулсан	Байгаль орчны хэсэг
Зорилт 2: Ойн санг хамгаалах, ногоон байгууламжийг сайжруулах								
4	Ногоон байгууламжийн хөрс боловсруулалт, арчилгаа усалгааг зохион байгуулах	10.0	ОНТ	Ажлын гүйцэтгэлээр	2024	2024 онд таригдсан модны ургалтын хувь хэмжээ 89.3 хувь	91%	Цэцэрлэгж үүлэлт ногоон байгуулам

	Ногоон байгууламжийн арчилгаанд шаардагдах дунд оврын ачааны машин худалдан авах	50.0	ОНТ	Ажлын гүйцэтгэлээр	2024	-	1	ЖИЙН ажилтан Байгаль орчны хэсэг	
6	Ногоон Жаргалант хөтөлбөрийн хүрээнд Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж хамгаалалтын ойн зурвас байгуулах	22.5	ОНТ	Ажлын гүйцэтгэлээр	2024	-	2	Байгаль орчны газар	
<b>Зорилт 3: Байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтыг дэмжих</b>									
7	Эргүүл хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	2.5	ОНТ	Хяналт шалгалт зохион байгуулсан тоо	2024	2024 онд 285 өрхөд сэрэмжлүүлэг мэдээ хүргэсэн	535	Байгаль орчны хэсэг, Цагдаагийн хэсэг	
8	Жаргалант багийн хойд хороололд байрлах ундны усны эх үүсвэрийн цооногийг бүрэн автомат төхөөрөмжөөр тоноглож, улсын нэгдсэн сүлжээнд холбох	45.0	ОНТ	-	2024	Сүлжээний ажлын гүйцэтгэлийн хувь 0%	100	Байгаль орчны газар	
9	Зүүн булгийн эх орчмын усны тэжээгдлийн бүсээр нь бүрэн хамгаалах, нөхөн сэргээх	13.5	ОНТ	-	2024	Зүүн булаг дахь хашигдсан талбайн хэмжээ 0 м2	450	Байгаль орчны газар	
10	Сумын 2025 оны төсөвт төвлөрүүлэх байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээр санхүүжүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ /БНАТ 2А мягтын дагуу/	25.05	БНАТ	-	2024	Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлт /гүйцэтгэлээр/	90	ЗДТГ ГХБХБГ	
<b>Нийт төсөв:</b>							<b>229.550 сая төгрөг</b>		